



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/42

Номгон

Монгол Улсын Төвийн бүсийн
“Аварга адуучин-2026” тэмцээн
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Соёлын өвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1.1, 1.2, 37.1, 39.1, 40.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төвийн бүсийн 10 аймгийн хэмжээнд Монгол түмний морьтны соёлыг өвлөн уламжлуулах, адуун сүргийг өсгөн үржүүлэх, эдэлгээ, уналгааг тохируулах, адуучдын ур чадвар, адуу маллагааны уламжлалт аргыг хөгжүүлж, дэмжих зорилгоор Монгол Улсын Төвийн бүсийн “Аварга адуучин-2026” тэмцээнийг 2026 оны 02 дугаар сарын 01-ний өдөр аймгийн төв стадионд зохион байгуулсугай.

2.Тэмцээнийг өндөр түвшинд зохион байгуулж, иргэд, адуучдын аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Биеийн тамир, спортын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Хүрэлчулуун), Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга (Б.Пүрэвдагва), Баянхонгор аймгийн Адуучдын холбооны тэргүүн (Б.Дэлгэрдалай) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Монгол Улсын Төвийн бүсийн “Аварга адуучин-2026” тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Наранбаяр

Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд:

Д.Энхжаргал

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга

Т.Цэвээндорж

Цагдаагийн газрын дарга

Г.Лхагва-Очир

Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч


62601003

Б.Пүрэвдагва	Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга
Д.Бат-Эрдэнэ	Онцгой байдлын газрын дарга
Ж.Уламбаяр	Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК-ийн захирал
Т.Отгонбаатар	Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын захирал
П.Уртнасан	Цэвэр хот ОНӨААТҮГ-ын дарга
Б.Ууганбаяр	SDY залуучуудын холбооны тэргүүлэгч
Нарийн бичгийн дарга:	
Б.Дэлгэрдалай	Баянхонгор аймгийн Адуучдын холбооны тэргүүн

4.Тэмцээнд зарцуулагдах 1,000,000 (Нэг сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.

5.Тэмцээний бэлтгэл ажлыг сайтар хангаж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

